



30

## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2012 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Дархан цаазат Богдхан уулын түүхэн дурсгал  
“Манзушир хийдийн очирваань чулуун хадан сийлбэр”  
сэргээн засварлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 49, 2006 оны 44, 2009 оны 4/22 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын аялал жуулчлал–2015 хөтөлбөрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Улаанбаатар хотын аялал жуулчлал–2015 хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Дархан цаазат Богдхан уулын түүхэн дурсгалт “Манзушир хийдийн Очирваань чулуун хадан сийлбэр” сэргээн засварлах ажлыг 2012 оны 05 сарын 12-ноос 14-ний өдрүүдэд хийж гүйцэтгэхийг атракци хариуцсан мэргэжилтэн /Д.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

Хоёр. Улаанбаатар хотын аялал жуулчлал–2015 хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Дархан цаазат Богдхан уулын түүхэн дурсгалт “Манзушир хийдийн Очирваань чулуун хадан сийлбэр” сэргээн засварлах ажлын зардал 5000000 /таван сая/ төгрөгийг Үндэсний болон дэд хөтөлбөрөөс гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Дээрх арга хэмжээг хөтөлбөрийн дагуу цаг хугацаанд нь амжилттай зохион байгуулж, олон нийтэд хэвлэл мэдээллээр сурталчилах, хяналт тавих, шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг хотын аялал жуулчлал хариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Баясгалан/-д даалгасугай.

ДАРГА



Ш.СҮХБААТАР

My Doc.\tushaal\

115.50000001